



**БАЯНХОНГОР АЙМГИЙН
БАЯН-ОВОО СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2023 оны 03 сарын 28 өдөр

Дугаар 1061

Хөхбүрд

┌ Дашигэмпил хийдийн шашны эд зүйлийг
соёлын өвд хамруулах, бүртгэх тухай ┐

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1.2, Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.3, 15.1.4, Төр, сүм хийдийн харилцааны тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2 дах заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга, аймгийн Засаг дарга нарын баталсан 2023 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн Шашны байгууллага, сүм, хийдүүдийн үйл ажиллагаанд хяналт, шалгалт хийх ажлын удирдамжаар ажилласан, ажлын хэсгийн зөвлөмжийг тус тус үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын аравдугаар хуралдаанаас ТОГТООХ нь:

1. Сумын нутаг дэвсгэрт буддын шашны чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг “Дашигэмпил” хийдийн бурхан шашинтай холбогдох эд зүйлд тооллого, бүртгэл, судалгаа хийж, соёлын өвд хамруулах, барилга, газар бусад хөдлөх болон үл хөдлөх хөрөнгийг сумын үндсэн хөрөнгөд тусгаж, бүртгэлжүүлэх ажлыг зохион байгуулсугай.

2. Тус хийдийн лам нарыг оролцуулан ажлын хэсэг байгуулж, бүртгэл судалгаа хийн, тайлан, мэдээг иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 11 дүгээр хуралдаанд танилцуулахыг сумын Засаг дарга (Ж.Хатанбаатар)-т даалгасугай.

3. Тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Төсөв санхүү, эдийн засгийн хөгжлийн хороо (Ц.Жаргалсайхан)-д үүрэг болгосугай.

ДАРГА  Б.ОТГОНБАЯР



648801051